



ӨНӨӨДӨР ДЭЛХИЙН ОЮУТНЫ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР



2017 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Оюутны холбооны нээлттэй чуулган зарлан хуралдлаа. Уг чуулганаар Геологи Уул Уурхайн Сургуулийн оюутан С. Болд-Эрдэнэ сонгогдож 20 гаруй мянган оюутнуудын эрх ашгийг хамгаалж, тэдний дуу хоолой болон ажиллах хүндтэй үүргийг хүлээн авлаа.

2017 оны 11 дүгээр сарын 17 “Дэлхийн оюутны эрхийг хамгаалах өдөр” Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Оюутны Холбооны нэрийн өмнөөс Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулиар овоглосон нийт оюутнуудад энэ өдрийн мэндийг хүргэе.

Биднийг дэмжин хамтран ажиллаж байгаа Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн захиргаа болон ШУТИС-мэдээлэл сонины хамт олондоо ажлын амжилт хүсье.

Оюутны Холбоо

Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэстэй хамтран ШУТИС-ийн оюутнууд 2017 оны 10 сарын 20-ноос 11 сарын 20-ныг хүртэл “Оюутан эргүүлд” ажиллаж байна.

Энэхүү “Оюутан эргүүл” нь амжилттай хэрэгжсэнээр Сүхбаатар дүүргийн 1-8 хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, Их дээд сургуулийн удирдлага, багш, ажилчид, оюутнуудыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, оюутан, залуусын нийгмийн хариуцлага, сахилга хүмүүжилд нөлөөлөх зорилготой юм.

СБД-ийн 8-р хороо хариуцсан ахлах дэслэгч Х.Наранбаатар эргүүлд ажиллах оюутнуудад Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5.1, 5.2, 6.3, 6.4, 6.5 хуулиудыг танилцуулан зааварчлагаа өглөө. Оюутан эргүүл ажилласнаар ШУТИС-ийн 1-р байр, 2-р байр, Технологийн төв байрны үүдэн дэх оюутнуудын тамхидалт эрс буурч байна.

Оюутан эргүүлд ГУУС-ийн оюутан Т.Анхбаяр, Э.Эрдэнэбат, Д.Энхтүвшин, Г.Пүрэвням, БАС-ийн оюутан Б.Батдэлгэр, Р.Очирваань, ҮТС-ийн оюутан Н.Нямдаваа, Ш.Мөнх-Од, Э.Энх-Учрал, М.Болор-Эрдэнэ нар ажиллаж байна.



“СПОРТЫН ХООЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН БАЙДААЛ” СЭДЭВТ СЕМИНАР АМЖИЛТАЙ БОЛОВ.

“ХҮРЭЛТОГООТ- 2017” ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН САЛБАР ХУРАЛ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗӨВЛӨЛ (АВЕТ)-ИЙН ШИНЖЭЭЧИД ШУТИС-Д АЖИЛЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ БАГШ, ДОКТОР ПРОФЕССОР Х.ПҮРЭВДАГВА БАГШИЙН “ҮНДЭСНИЙ МЕНЕЖМЕНТИЙН СУДЛАА, СУРГААЛ- 45 ЖИЛ” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

ШУТИС-Д НИЙГМИЙН АЖЛЫН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 20 ЖИЛИЙН ХААЛТЫН БАЯРЫН ХУРАЛ БОЛОО.

ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХАНДАЛТЫН СУДАЛГАА

ШУТИС.БАС-ИЙН АРХИТЕКТУРЫН САЛБАР ПАРИС ХОТЫН ЛА ВИЛЛЕТТИЙН АРХИТЕКТУРЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГ ЭЭЛЖИТ НАМРЫН СУРГААЛ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.

БАС-ИЙН ОЮУТНУУД ОХУ-ЫН ЕКАТЕРИНБУРГ ХОТЫН УРАЛЫН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАЖ ЭХЭЛЭЭ

“ХООЛЗҮЙЧ”-ИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГААЛ- NUTRITION CARE PROCESS СЭДВИЙН ХҮРЭЭНД АМЖИЛТАЙ БОЛОО

ШУТИС-ИЙН ПРОФЕССОР БАГШ НАРЫН БҮТЭЭЛ- 2017

“ХҮРЭЛТОГООТ- 2017” ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН САЛБАР ХУРАЛ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАА



БСШУСЯ, ШУА, ШУТИС, ШУТС, МЗЭХ болон ТИЗСН-ээс техник, технологийн салбарын залуу судлаачдын дунд “Хүрэлтогоот” эрдэм шинжилгээний хурлыг 13 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэ жилийн “Хүрэлтогоот-2017” эрдэм шинжилгээний хурал 2017 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн төв номын сангийн хурлын 604 тоот танхимд болсон бөгөөд хурлын үйл ажиллагаанд 120 гаруй залуу эрдэмтэн судлаачид,

албаны хүмүүс оролцлоо. Хурлын үйл ажиллагааг нээж БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа сайд үг хэллээ. Сайд Ц.Цогзолмаа боловсролын салбар, дээд боловсрол, шинжлэх ухаан, инновацийн эрхзүйн орчныг цаашид улам боловсронгуй болгох чиглэлээр ажиллахаа тэмдэглэж, эрдэмтэн судлаач, үйлдвэрлэгчдийн бий болгосон шинжлэх ухаан, инновацийн ажлын үр дүн манай улсын баялаг, хөгжлийн үндэс болох учиртайг онцлов.



Түүнчлэн бүх шатны эрдэмтэн судлаач, багш нарын хөдөлмөрийг бодитой үнэлэх, хүндээ хөрөнгө оруулалт хийх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд салбар хариуцсан сайдын хувьд дэмжиж ажиллахаа илэрхийлэв. Инноваци, шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг цаасан дээр бус, бодит үйл хэрэг болгох ажлуудыг залуу эрдэмтэн судлаачидтайгаа хамтран хэрэгжүүлж эхлүүлэхээ мэдэгдэв. ТИЗСН-ийн дэд тэргүүн Б.Арвинбаяр, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан, МЗЭХ-ны ерөнхийлөгч Д.Баттогтох нар хуралд оролцогчид болон шинээр томилогдсон сайдад ажлын амжилт хүсч, цаашид инновацийн чиглэлээр Хүрэл тогоотын тэтгэлэг олгодог болгох, залуу судлаачдын үйл ажиллагаа болон төрөөс явуулж буй бодлогыг дэмжиж ажиллах талаар талархлын үг хэлэв. Тус хурлын уламжлал болгон хэлэлцүүлдэг хүндэтгэлийн илтгэлийг УИХ-ын гишүүн Н.Учрал тавив. Тэрээр өнгөрсөн хугацаанд инноваци, мэдлэгийн эдийн засгийг бий болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр эрхзүйн орчин бүрдсэн бөгөөд түүний хэрэгжилт хангалтгүй байгааг дурдлаа. Цаашид инновацийн эрхзүйн орчныг сайжруулах, инновацийн санг дахин бий болгох, инновацийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, энтрепренер

их сургуулиудыг бий болгох, гарааны компанийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр бодитой ажлуудыг, бодлогуудыг хэрэгжүүлэхэд УИХ, Засгийн газрын зүгээс эрчимтэй ажиллах болно гэдгийг онцлон тэмдэглэв. Манай хурлын нээлттэй илтгэлийг МЗЭХ-ны хүндэт гишүүн Б.Ганбат тавьлаа. Үндэсний инновацийн тогтолцоог бий болгох, инновацийн чиглэлээр нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээний талаар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв. Тус хурлын шүүгчээр академич Ж.Тэмүүжин, Шинэ монгол технологийн дээд сургуулийн захирал Ч.Ганзориг, Герман–Монголын технологийн сургуулийн захирал Н.Дорждэрэм, МУИС-ийн багш доктор, дэд профессор Ч.Лодойравсал, ШУТС-ийн захирал Д.Энхжаргал, “Оттотех” компаний ерөнхий захирал Т.Гансүлд зэрэг салбартаа нэр хүнд бүхий тэргүүлэх эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүс ажиллаж, залуу судлаачдын эрдмийн ажлыг шүүн хэлэлцлээ. Жил бүр өргөжин тэлж буй тус эрдмийн хурлын арга хэмжээнд Австрали, ОХУ, Япон, Тайвань, Солонгос, Монгол зэрэг 6 улсаас нийт 100 гаруй залуу эрдэмтэн, судлаачдын 50 гаруй бүтээл ирүүлснээс анхан шатны шалгаруулалтаар 87 судлаачдын 36 бүтээлийг эмхтгэн олон нийтэд толилуулж байгаа бөгөөд дараагийн шатанд суурь болон хэрэглээний чиглэлээр тус бүр долоон илтгэл шалгарч, гурав дахь шатанд хэлэлцүүлсэн.



ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗӨВЛӨЛ (АВЕТ)-ИЙН ШИНЖЭЭЧИД ШУТИС-Д АЖИЛЛАВ.



ШУТИС-ийн МХТС-ийн Холбооны салбарын Цахилгаан холбоо болон Утасгүй холбоо бакалаврын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэхээр

утасгүй холбоо хөтөлбөрүүд инженер технологийн магадлан итгэмжлэлийн бакалаврын хөтөлбөрийн шалгуур, шаардлагуудыг "хангасан" гэсэн үнэлгээг

ёсоор мэдэгдэх журамтай юм байна.

АВЕТ байгууллага нь хэрэглээний болон байгалийн шинжлэх ухаан, компьютер, инженерчлэл ба инженер технологийн гэсэн 4 дэд зөвлөлөөр их дээд сургуулиуд болон боловсролын хөтөлбөрүүдэд магадлан итгэмжлэл хийдэг 85 жилийн түүхтэй, үйлдвэрлэл, их дээд сургууль, хувийн хэвшлийг төлөөлөх 2200 гаруй шинжээчид бүхий олон улсад нэр хүндтэй магадлан итгэмжлэлийн байгууллага юм. АВЕТ нь 2017 оны 10-р сарын байдлаар 31 орны 776 коллеж, их, дээд сургуулиудын 3852 хөтөлбөрийг магадлан итгэмжлээд байгаа юм байна.

ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдийг АВЕТ байгууллагаар олон улсад магадлан итгэмжлүүлснээр Монголын инженер, технологийн



АНУ-ын Балтимор мужид төвтэй инженер, технологийн магадлан итгэмжлэлийн зөвлөл (АВЕТ)-ийн олон улсын шинжээчид 2017 оны 10 сарын 29-31-ний өдрүүдэд тус сургууль дээр ажиллалаа. Энэ үйл ажиллагаанд "Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл"-ийн судалгаа хөгжүүлэлт, төсөл хариуцсан мэргэжилтэн Ц.Батбаяр хөндлөнгийн ажиглагчаар оролцсон юм.

Эдгээр хөтөлбөрүүд нь Монгол улсад төдийгүй Азид анх удаа АВЕТ-ийн ЕТАС буюу инженер технологийн магадлан итгэмжлэх зөвлөлөөр магадлан итгэмжлүүлж байгаагаараа онцлог юм.

3 өдрийн хугацаанд шинжээчид магадлан итгэмжлэлийн 9 шалгуурын дагуу холбогдох нотлох баримтуудыг хянах, ШУТИС, МХТС-ийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, багш нар, ажил олгогчид, төгсөгчид, оюутнуудын төлөөлөлтэй уулзалт хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсан бөгөөд шинжээчдийн дүгнэлтээр цахилгаан холбоо,

аваад байна.

Энэ үнэлгээг 2018 оны 6-р сард болох АВЕТ байгууллагын удирдах зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталгаажуулсны дараа ШУТИС-д албан

боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөх, төгсөгчид мэргэжлээрээ олон улсад ажиллах, ахисан түвшний сургалтуудад хамрагдах зэрэг олон давуу талууд бий болно.



МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ БАГШ, ДОКТОР ПРОФЕССОР Х.ПҮРЭВДАГВА “ҮНДЭСНИЙ МЕНЕЖМЕНТИЙН СУДЛАЛ, СУРГАЛТ-45 ЖИЛ” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.




Тус арга хэмжээний хүрээнд :

Бизнесийн удирдлагын салбарын оюутнуудын дунд “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО-МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛД” мэтгэлцээний тэмцээн 2017 оны 09 сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулагдаж , тус салбарын багш нар болон оюутан залуус идэвхитэй оролцлоо. Тус тэмцээнийг “Бэхи цолтон” ТББ ивээн тэтгэв.

БАТС, БУСалбар, Төгсөгчдийн холбоо хамтарч 2017 оны 10 сарын 13 нд “Төгсөгч шавь нарын уулзалт”-ыг зохион байгуулсан бөгөөд үе үеийн төгсөгч шавь нар оролцож, Доктор, профессор Х.Пүрэвдагва “Орчин үеийн менежментийн чиг хандлага”, ШУТИС-ийн хүндэт профессор Д.Жаргалсайхан “Систем нь зорилгыг хэрэгжүүлэгч арга мөн”, Доктор, дэд профессор Г.Баттүвшин “Бизнесийн ахисан түвшний сургуулийн өнөөгийн төлөв, цаашдын хандлага”, Доктор Д.Ганбаатар “Бизнесийн байгууллагын хамтын ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлээ.

Үндэсний менежментийн судлал, сургалт-45 жил” , менежментийн түүхэн хөгжил, сургалт, хөтөлбөрийн талаар Монголын Үндэсний телевиз, TV8, Oloo tv, TV9, Eagli tv зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилав.

“ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн профессор, доктор профессор Х.Пүрэвдагвын “Үндэсний менежментийн шавь судлал, сургалт-45 жил” эрдэм шинжилгээний хурал 2017 оны 10 дугаар сарын 27-ны зохион байгуулагдлаа. Хурлын үеэр “Зураг түүх өгүүлнэ”, Доктор, профессор Х.Пүрэвдагва багшийн “БҮТЭЭЛ”-ын үзэсгэлэнг гаргаж толилуулав.



Хурлын үйл ажиллагаанд УБХ-ын дарга, УИХ-ын дарга асан, Академич, доктор профессор Р.Гончигдорж, Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн Академич, Доктор(ScD) профессор Т.Дорж, Монгол Улсын гавъяат эдийн засагч, УБХ-ын гишүүн, УИХ-ын гишүүн асан доктор профессор

Д.Балдан-Очир, Монгол Улсын болон ОХУ-ын Буриад улсын гавъяат барилгачин Б.Жүгдэр, Монгол Улсын гавъяат багш, доктор профессор Я.Шуурав, Д.Цэрэндорж, Монголын их дээд сургуулиудын удирдлага, профессор багш нар, БУХС, БАТС-ийн багш нар болон шавь нар, гэр бүл, номын нөхөд нь оролцлоо.



Хэлэлцүүлэгт төр нийгмийн зүтгэлтнүүд, академичид, бизнесийн байгууллагын төлөөлөгчид, нутгийн зөвлөл, профессор багш нар Профессор Х.Пүрэвдагвын Үндэсний менежментийн судлал, сургалтанд зориулсан 45 жилийнх нь хөдөлмөр бүтээлийг шүүн хэлэлцэж, өндрөөр үнэлсэн юм.

Доктор, профессор Х.Пүрэвдагва багш маань төр засгаар хөдөлмөрөө үнэлүүлэн “ Монгол улсын гавъяат багш ” цол тэмдгээр шагнагдсан нь олны талархалыг хүлээсэн, баярт үйл явдал байлаа.



“Үндэсний менежментийн шавь судлал, сургалт-45 жил” эрдэм шинжилгээний хуралд:

- “Доктор, профессор Х.Пүрэвдагва багшийн менежмент судлалд оруулсан хувь нэмэр” сэдвээр Доктор(Sc.D), профессор Г.Батхүрэл,

- “Үндэсний менежментийн шавь сургуулийн сургалтын уламжлал, шинэчлэлт” сэдвээр доктор (Ph.D), профессор Б.Энхтуяа,

- “Эрдмээр жигүүрлэсэн Эрдмийн шувууд цомын аялал” сэдвээр ШУТИС-ийн Хүндэт профессор Д.Жаргалсайхан

- “Доктор, профессор Х.Пүрэвдагвын Монголын менежментийн салбарын багш нарын хамтын ажиллагаа, залуу үеийг бэлтгэхэд оруулсан хувь нэмэр” сэдвээр Доктор (Ph.D), профессор Ц.Цэцэгмаа нар илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Монгол улсын гавъяат багш, доктор профессор Х.Пүрэвдагва багшийг ШУТИС-ийн удирдлага хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ

ШУТИС-Д НИЙГМИЙН АЖЛЫН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 20 ЖИЛИЙН БАЯРЫН ХУРАЛ БОЛОО.

Монгол улсын нийгмийн ажлын шинжлэх ухааны хөгжлийн 20 жил, ШУТИС-д нийгмийн ажлын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 20 жилийн хаалтын баярын хурал нь салбарын ололт, амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох, байгууллага, олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, багш, оюутан, төгсөгч, нийгмийн ажилтнуудын хөдөлмөр бүтээл, алдар гавьяаг алдаршуулах зорилгоор зохион байгуулагдсан.



Тус ойн арга хэмжээний хүрээнд:

1. Нийгмийн ажлын хөгжлийн үр дүнг нэгтгэх, салбар дундын уялдаа холбоог хангах, мэргэжлийн хамтын ажиллагаа, олон улсын туршлагаас суралцах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор "НИЙГМИЙН АЖИЛ- НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ" олон улсын эрдэм шинжилгээний хурал
2. Төгсөгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Спортын 4 төрөлт тэмцээн
3. "Нийгмийн ажил мэргэжлийн түүхэн замнал 20" түүхийн ном бичих зэрэг зорилтот үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ухааны салбарын Нийгмийн ажлын хөтөлбөрийн профессор багш нар чармайн ажилласан.

Энэхүү баярын хуралд ШУТИС-ийн хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал Т.Намнан, БУХС-ийн захирал доктор, дэд профессор А.Энхбат, салбарын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, нийгмийн ажлын хөтөлбөрийн багш, оюутнууд, 2001-2017 онуудын 17 төгсөлтийн төгсөгч нар хүрэлцэн ирсэн. Мөн үүний зэрэгцээ ХНХЯ, БСШУСЯ, ХХҮЕГазар, МУБИС, МУИС, АШУИС, Идэр ДС, Хөдөлмөрийн харилцааны ДС, "Хүүхдийг ивээх сан" (Япон), "Дэлхийн зөн" ОУБ, "Каритас Чех" ОУБ, "Good Neighbors Монгол" ОУБ, Сонгдо групп, ДАМОСТ, "Гүнж" төв, "Хөөрхөн зүрхнүүдийн аян", Нийгмийн ажлын багш, сургагчдын холбоо, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, "Түгээмэл хөгжил" ТТБ зэрэг хамтран ажилладаг төрийн ба төрийн бус, олон улсын байгууллагын төлөөллүүд хүрэлцэн ирсэн байна.

төгсөгчдийн бахархал болсон доктор, профессор А.Энхбаатар, доктор, профессор Т.Амаржаргал, доктор, профессор Н.Галиямаа, доктор, дэд профессор Б.Даваажав, доктор, дэд профессор Д.Ганболд, ахмад багш С.Биндэръяа, доктор, дэд профессор Д.Сэрдарам нартаа хүндэтгэл үзүүлэв.

Нийгмийн ажлын шинжлэх ухааны талаар өргөн мэдлэгтэй, орчин үеийн нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ практикт хэрэглэх чадвартай, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтэд өөрийн мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлж байдаг, хувь хүн, бүлэг, олон нийттэй ажиллах арга барилыг эзэмшсэн, нийгмийн судалгаа хийх чадвартай, харилцааны өндөр соёлтой, нийгмийн ажлын ёс зүйг эрхэмлэдэг мэргэжилтэн бэлтгэх их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе!



Тус сургуулиас нийгмийн ажилтан мэргэжлийн бакалавр 657, магистр 120, докторант оюутан 30 төгсөж, нийгэм, хүмүүнлэгийн салбарын зах зээл дээр нэр хүндтэй ажиллаж хөдөлмөрлөж байна. "Нийгмийн ажил" мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлсэн ололт амжилтаа бататган, цаашид олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

Нийгмийн ажлын мэргэжилтэн бэлтгэх их үйлсийн үндсийг тарьж, сургалтын хөтөлбөрийг сайжруулахад өөрийн мэдлэг, чадвараа дайчлан ажиллаж байгаа, үе үеийн багш нар болон




ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХАНДАЛТЫН СУДАЛГАА

Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн 20 орчим олон улсын мэдээллийн сангийн эрхийг авч судлаачдын хүртээл болгож байна. Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалт, статистик, татгалзлын судалгааг тогтмол гарган үр дүнгээс хамаарч цаашид ямар төрлийн мэдээллийн сан эрэлт хэрэгцээтэй байгаад дүгнэлт хийж, тухайн салбарын мэдээллийн сангийн эрх авах, е-номын захиалгад тусган ажиллаж байна.


Номын сангаас мэдээллийн сангийн үйлчилгээг хүргэхээс гадна судлаачдын ОУ-ын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлийн тоо, тэдгээрийн эшлэгдсэн байдал, мэдээллийн санд хандсан хандалт зэрэг статистикуудийг тогтмол гарган мэдээлдэг.

22000 орчим мэргэжлийн сэтгүүлийг нэгтгэсэн SCOPUS мэдээллийн сангаас ШУТИС-ийн багш нарын бүтээлийн хэвлэгдсэн өгүүлийн тоо, тэдгээрийн эшлэгдсэн байдлыг тоймлон дараах байдлаар үзүүлж байна.

Эх сурвалж: SCOPUS мэдээллийн сан




Scopus



Copyright © 2017 Elsevier B.V. All rights reserved. Scopus® is a registered trademark of Elsevier B.V.

"Springer Nature" мэдээллийн сангийн сэтгүүлийн таталт



БСШУСЯ-ны санхүүжилтээр 2016-2021 оны хооронд Шинжлэх ухааны академи, төрийн тэргүүлэх 5 сургуулиуд "Springer Nature" мэдээллийн сангийн 1800 орчим сэтгүүлийг ашиглах эрхтэй болсон.

Springer Nature-т 2017 оны 10 сарын 30-ны байдлаар 29560 таталт, 1619 татгалзал бүртгэгдсэний эхний 10 сэтгүүлийн харьцуулсан судалгааг гаргав.

Сэтгүүлийн таталт			Сэтгүүлийн татгалзал		
Total for all journals			29560	Reporting Period Total	1619
1	Somnologie	1292	Somnologie	340	
2	Cryptography and Communications	606	Cryptography and Communications	51	
3	Food and Bioprocess Technology	538	Food and Bioprocess Technology	42	
4	International Journal of Automotive Technology	449	International Journal of Automotive Technology	39	
5	Constitutional Political Economy	428	Constitutional Political Economy	35	
6	Frontiers of Physics	296	Frontiers of Physics	34	
7	Communications in Mathematical Physics	281	Communications in Mathematical Physics	33	
8	Journal of Geographical Sciences	272	Journal of Geographical Sciences	32	
9	Hydrobiologia	260	Hydrobiologia	28	
10	Israel Journal of Health Policy Research	251	Israel Journal of Health Policy Research	27	

Номын татгалзал



№	Total for all titles	Reporting Period Total
		16519
1	Encyclopedia of Complexity and Systems Science	282
2	Encyclopedia of Migration	241
3	Handbuch Controlling der Kommunikation	180
4	Handbook of Geomathematics	124
5	Critical Care Toxicology	122
6	Algorithms - ESA 2015	109
7	Handbook of Antenna Technologies	109
8	Quirky Quarks	108
9	Handbook of Paleoanthropology	99
10	L-Arginine in Clinical Nutrition	99

2017 – 2018 оны хичээлийн жилд цахим мэдээллийн нөөцөө баяжуулах, судлаачдын мэдээлэл авах цар хүрээг өргөжүүлэх зорилгоор EBSCO олон улсын мэдээллийн санг дахин захиалах ажлыг эхлүүлэн 2017 оны 10 дугаар 2-ны өдрөөс 2 сарын хугацаатай инженерийг чиглэлийн Energy & Power Source (EPS), Applied Science & Technology Source Ultimate, Engineer-

ing Source, Computer & Applied Sciences Complete багцуудын туршилтын эрхийг нээж профессор багш, оюутан судлаачдад хүргэж байна. Туршилтын хугацааны судлаачдын хэрэглээний статистикийг үндэслэн цаашид захиалах тул та бүхнийг сургалт судалгааны ажилдаа идэвхтэй ашиглахыг хүсэж байна.

EBSCO мэдээллийн сангийн хандалтын статистик / 2017.10.02-10.26 /

№	Title	Publisher	Subject
1	Utility Week	Faversham House Group Limited	Banking, Finance & Investing
2	Journal of Educational Computing Research	SAGE Publications	Education (General)
3	Communications of the ACM	ACM / Association for Computing Machinery	Computer Science
4	ComputerWorld Hong Kong	Questex Media Group	
5	Journal of Educational Technology Systems	SAGE Publications	Computer-Assisted Instruction

Ebsco мэдээллийн санд хандалт хийсэн байдал					
Database	Database Sessions	Total Searches	Total Requests	Total Full-Text Requests	Abstract Requests
Applied Science & Technology Source Ultimate	11	37	26	19	7
Computers & Applied Sciences Complete	12	39	78	36	42
Energy & Power Source	10	27	11	11	0
Engineering Source	12	36	33	25	8

ШУТИС.БАС-ИЙН АРХИТЕКТУРЫН САЛБАР ПАРИС ХОТЫН ЛА ВИЛЛЕТИЙН АРХИТЕКТУРЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭЭЛЖИТ НАМРЫН СУРГАЛТ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.



ШУТИС.БАС-ийн Архитектурын салбар Парис хотын Ла Виллетийн Архитектурын Үндэсний Их Сургуультай хамтран зохион байгуулдаг ээлжит намрын сургалт, судалгааны 5 дахь удаагийн сургалтыг 2017 оны 10 сарын 11-нд Улаанбаатар хотод амжилттай зохион байгууллаа. Намрын сургалтын хүрээнд Архитектурын салбарын 3 ба 4-р курсын нийт 9 оюутан Францын 8 оюутантай хамтран Улаанбаатар хотын сонгосон 4 байршилд хот байгуулалт, амьдрах орчны судалгаа гүйцэтгэж, судалгааны урьдчилсан үр дүнг Нийслэлийн Захирагчийн Ажлын Алба, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт танилцуулав.

Сургалтын явцад Парис хотын Ла Виллетийн Архитектурын Үндэсний Сургуулийн багш Оливер Бушерон

Барилга захирал цаашдын

Архитектурын Э.Нинжгаравтай хамтын

Сургуулийн уулзаж ажиллагааг

өргөжүүлэх боломж бололцооны талаар санал солилцлоо.

БАС-ИЙН ОЮУТНУУД ОХУ-ЫН ЕКАТЕРИНБУРГ ХОТЫН УРАЛЫН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАЖ ЭХЭЛМЭЭ

ШУТИС-ийн БАС болон УрФУ-ын хамтын ажиллагааны гэрээний дагуу "Ус хангамж, ус цэвэрлэгээ" мэргэжлийн магистрын 1+1 хамтарсан хөтөлбөрийн хүрээнд БАС-ийн 6

оюутан ОХУ-ын тэтгэлгээр сурч эхэллээ. Суралцах хөтөлбөрийн дагуу хэлний бэлтгэл, магистрын 1-р ангийн хичээлийг УрФУ-д, 2-р ангийн хичээл болон дипломын төслөө ШУТИС-

даа суралцаж хамгаална. Төгсөлтийн хамтарсан комиссын шийдвэрээр хоёр сургуулийн магистрын дипломтой төгсөнө.

EZCON КОМПАНИЙ ЭЭЛЖИТ ТЭТГЭЛЭГТ БАС-ИЙН ОЮУТНУУД ХАМРАГДЛАА



Энэ удаагийн тэтгэлэгт хөтөлбөрт ББЭТ мэргэжлийн оюутан З.Төгөлдөр, Н.Анхчимэг, БМҮТ мэргэжлийн оюутан Т.Амардалай, Э.Мөнхбаяр,

В.Оюунбаяр, М.Энхмаа, ИБҮБ мэргэжлийн оюутан С.Түвшинбаяр, Ө.Урантогос, архитектур мэргэжлийн оюутан С.Алтангэрэл, сантехникийн

БНСУ-ын зуун хувийн хөрөнгө оруулалттай EZCON буюу "И Зэт Си Өү Эн" ХХК нь 2009 онд байгуулагдан Монгол улсад бетон зуурмагийн шинэ технологийг нэвтрүүлэх, түүнийг таниулах, зах зээлд нийлүүлэх зорилгоор БАС-ийн Барилгын материалын технологийн багш нар, Барилгын дэвшилтэт материал, бүтээцийн судалгааны төвтэй хамтран туршилт, судалгааны ажлыг хийж байна. Хамтын ажиллагааны бас нэг чиглэл нь жил бүр сурлага, хүмүүжлээрээ тэргүүний 10 оюутанд "И Зэт Си Өү Эн" ХХК -ийн тэтгэлэг олгодог. Эдгээр оюутнуудыг сонгохдоо сурлагын үзүүлэлтээс гадна амжиргааны түвшинг нь харгалзан үздэг.

инженерийн байгууламж мэргэжлийн оюутан О.Жаргалсайхан нарын 10 оюутан хамрагдлаа.

ТӨМӨРБЕТОНЫ АЯН-2017

ШУТИС-ий Барилга Архитектурын Сургуулийн Барилгын Инженерийн Салбараас жил бүр зохион байгуулдаг "Төмөрбетоны аян" тэмцээн 2017 оны 09 сарын 18-с 10-р сарын 26-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү аяны зорилго нь "Төмөрбетон бүтээц" хичээлээр олж авсан мэдлэгээ баталгаажуулах, онол практикийг хослуулах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой юм. Энэхүү аяны үйл ажиллагаанд ШУТИС-н Барилга Архитектурын Сургууль, Үндэсний

Батлан Хамгаалахын Их Сургууль, Техник Технологийн Дээд Сургууль, Үндэсний Их сургуулийн 100 гаруй оюутны 17 баг оролцсоноос:

-1-р байр "IMMENSE", 2-р байр "SUFFICIENT", 3-байр "BEAM BROS" /ТТДС/ багууд эзэлсэн ба, тусгай байрт "FLAME", "INF", "Практик", "B14x6" багууд, шилдэг илтгэлд "BEAM BROS", шилдэг ханын илтгэлд "IMMENSE" багууд шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ.

ШУТИС. БАС ТӨГСӨГЧ ОЮУТНУУДАА ЗОРИУЛАН ЗОХИОН БАЙГУУЛДАГ "АЖЛЫН БАЙР ТАНИЛЦУУЛАХ-JOB FAIR 2017" ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ АРГА ХЭМЖЭЭГ КАНАДЫН ЮНИТЕРРА ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



Уулзалт арга хэмжээний үеэр Юниетерра хөтөлбөрийн зөвлөх Yves Carmel "Ногоон барилга" сэдвээр, Юниетерра хөтөлбөрийн хүний нөөцийн зөвлөх Ossama Mazbouh "Ажилд сонгон авах болон тогтоон ажиллуулах" сэдвээр, NCD группын

Бизнес Хөгжлийн Захирал П.Алтантуяа "NCD группын танилцуулга, ажил олгогчийн зүгээс оюутнуудаас хүсэх зүйл" сэдвээр, Ультрасоник ХХК-ийн маркетингийн менежер Отгонбаяр "Ультрасоник компанийн танилцуулга, үйл ажиллагаа ажлын байр" сэдвээр

Уулзалт арга хэмжээний зорилго нь: БАСургуульд суралцаж буй ахлах курсын бүх мэргэжлийн оюутнуудад томоохон барилгын компаниудад хэрхэн ажилд орох, ажлын байр танилцуулах, компаниуд өөрсдийн захиалгат боловсон хүчнийг сонгож аван сургалтын төлбөрийг даах, дадлага хийх боломж нөхцлөөр хангаж ажлын байртай болгох үндсэн зорилготой. Энэ удаагийн уулзалт арга хэмжээг Канадын Юниетерра олон улсын байгууллага, Барилгын Үндэсний Ассоциаци хамтран зохион байгуулж, Номин "NCD"групп, Ультрасоник ХХК, М-Си-Эс групп, Роял Нью Кэстл ХХК, Макс Өргөө ХХКомпаниудын үүний нөөцийн мэргэжилтнүүд оролцож, ажлын байр, хэрхэн ажилд орох талаар зөвлөгөө өгч оюутнуудын сонирхсон асуултанд хариуллаа.

тус тус сонирхолтой илтгэлүүдийг тавилаа. Уулзалтын үеэр Канадын Юниетерра олон улсын байгууллагаас эрхлэн гаргасан "Модон байшингийн төсөл тооцооны удирдатгал" гарын авлагыг профессор багш оюутнуудад гардуулан өглөө.



“СПОРТЫН ХООЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН БАЙДАЛ” СЭДЭВТ СЕМИНАР АМЖИЛТАЙ БОЛОВ.



ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургууль (ҮТС) болон БНСУ-ын “WITH” Төрийн Бус Байгууллага болон Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газар хамтран “Спортын хоол, шим тэжээлийн байдал” сэдэвт семинарыг 2017 оны 10-р сарын 4-нд Шинжлэх ухаан технологийн номын сангийн хурлын танхимд зохион байгууллаа.

Семинарыг нээж ШУТИС, Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн захирал Ж.Туяацэцэг, “WITH” ТББ-ын Монгол дахь төлөөлөгч Пак Гён Хи болон ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн Тамир Спортын Газрын Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Ц.Одонбаяр нар үг хэлэв.

Семинарын хөтөлбөрийн дагуу БНСУ-ын “ТЭРИН” үндэсний спортын цогцолборын хоолзүйч, доктор Cho Seong Suk уригдан ирж “Олон улс дахь спортын хоол, шим тэжээлийн хөгжил ба ирээдүй: БНСУ, Япон, Австрали улсын жишээ” болон “Спортын

амжилтанд зүүлэх хоол, шим тэжээлийн нөлөө” сэдвээр маш сонирхолтой илтгэл тавьж, зарим алдартай тамирчдын бэлтгэл болон тэмцээний үеийн хооллолтын тухай илтгэл танилцуулав. ШУТИС, ҮТС-ийн Биотехнологи, Шим судлалын тэнхимийн профессор Г.Энхтайван “ШУТИС, ҮТС болон Биеийн Тамир Спортын Газрын хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийсэн ажлын тайлан”, Биеийн Тамир Спортын газрын Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний албаны эрдэм шинжилгээний ажилтан, МУ-ын гавъяат дасгалжуулагч, ШУ-ны доктор, профессор Л.Ням “Үндэсний шигшээ багийн тамирчдын эрүүл мэнд, хоол, шим тэжээлийн өнөөгийн байдал”, МУИС-ын сэтгэл судлалын багш, Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгийн захирал, докторант Б.Золзаяа “Тамирчдын амжилтанд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдлэг, хандлага, зан үйл” сэдвээр тус тус илтгэл тавив.

Энэхүү семинарт Биеийн Тамир Спортын Газрын Төрийн захиргааны

удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Ц.Одонбаяр, Үндэсний шигшээ багийн албаны дарга Э.Билэгт, Спортын Анагаах ухааны эрдэм шинжилгээний албаны ЭША Б.Эрдэнэваанчиг, Б. Чаминчулаан болон тус албаны эмч Ш.Болормаа, Ш.Өсөхбаяр болон бусад багш, дасгалжуулагч, тамирчид, Олимпын хорооны Допингийн эсрэг үндэсний хорооноос Г.Сүхбат, МУ-ын Боловсролын их сургуулийн Биеийн тамирын сургуулийн багш, Аварга дээд сургуулийн багш, дасгалжуулагч, Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв, Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн хоолзүйчид, суралцаж буй оюутнууд зэрэг нийт 108 хүн хамрагдлаа. Семинарын хүрээнд олон улсын спортын шинжлэх ухааны хөгжлийн түвшин, БНСУ-ын тамирчдын бэлтгэл болон тэмцээний үеийн хооллолтын тухай мэдээлэл авч, Монгол улсын хэмжээнд спортын хоолзүй, шим тэжээлийн талаар сургалт, судалгааг хийх цаашид тамирчдын ирээдүйн амжилтанд салбар бүрийн мэргэжилтнүүд бүгд хамтран ажиллах нь зүйтэй гэдэгт санал нэгдэв.

“ХООЛЗҮЙЧ”-ИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ- NUTRITION CARE PROCESS СЭДВИЙН ХҮРЭЭНД АМЖИЛТАЙ БОЛОО



ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургууль (ҮТС) болон БНСУ-ын “WITH” Төрийн Бус Байгууллага болон Шим Тэжээл Судлалын Төв (ШТСТ) хамтран “Хоолзүйчийн мэргэжил дээшлүүлэх 6 дахь удаагийн эрчимжүүлсэн сургалтыг Nutrition Care Process” сэдвийн хүрээнд 2017 оны 10-р сарын 5-нд зохион

байгууллаа. Энэхүү сургалтын зорилго нь олон улсын шим тэжээлийн үйлчилгээний системийн тухай хоолзүйчдэд мэдлэг олгох, мэргэжлээ дээшлүүлэх болон хоорондоо туршлага солилцох юм. Сургалтанд урилгаар БНСУ-ын “Ажү” эмнэлгийн эмчилгээний хоолны тасгийн эрхлэгч доктор Choi Sun Jung ирж олон улсын шим тэжээлийн үйлчилгээний системийн


талаар илтгэл тавьж хоолзүйчдын асуултанд хариулав. Мөн “Ажү” эмнэлгийн эмчилгээний хоолзүйчийн мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтанд хамрагдсан Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээний хоолзүйч Д.Намжилмаа сургалтын тухай, БНСУ-ын эмчилгээний хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон шим тэжээлийн үйлчилгээний системийн талаар илтгэл танилцуулав. Энэхүү семинарт нийт эмнэлэг, эрүүл мэндийн төв, амбулатори, өрхийн эмнэлэг болон бусад байгууллагад ажиллаж буй эмчилгээний хоолзүйчид хамрагдав.

ШУТИС-ИЙН ПРОФЕССОР БАГШ НАРЫН БҮТЭЭЛ- 2017

МАНАЙ ЭРДЭМТЭД ЦУВРАЛ БҮТЭЭЛ



УУЛ УУРХАЙ, ГЕОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР



Зохиогч: Гордниченко В.И., Дмитриев А.П., Очирбат П., Дондов Д., Пүрэв Л.
Он: 2017
Хуудас: 990
ISBN 978-99978-05-72-0

Уулын чулуулыг бутлах процесс, уулын цулыг зөөх, тээвэрлэх, уулын машин механизмын хийц ангилал, ажилгааны зарчмыг өгүүлнэ. Уулын малталтыг бэхлэх, агааржуулах, гэрэлтүүлэх, уурхайн талбайг хатаах процессыг нэг бүрчлэн тайлбарласан байна.



Зохиогч: Жаргалант С., Энхжаргал Б., Алтанхуяг Д.
Редактор: Гарамжав Д., Сэрмаа Г.,
Он: 2017
Хуудас: 276
ISBN 978-99978-05-72-0

Метал ашигт малтмалын үндсэн ойлголт, тэдгээрийн ангилал, хэрэглээ, хүдрийн голлох эрдсүүд, ордуудын гарал үүсэл, тухайн ордуудын харьяалагдах хүдрийн нөөц, баялгийн талаарх ухагдахууныг энэхүү номноос уншина.




Зохиогч: Наранцэцэг Б., Алтанцэцэг Д.
Редактор: Гантөмөр С.
Он: 2017
Хуудас: 149
ISBN 978-99978-05-72-0

Номонд шугам хоолой, түүний арматур, холбогч болон бусад эд ангиудын сонголтын үед хийгдэх зарим тооцооны аргачлал болон сонголтонд ашиглах материалуудыг тусгалаа.



Зохиогч: Ухнаа Г., Алтанзул Б.
Редактор: Алтанхуяг Д.
Он: 2017
Хуудас: 166
ISBN 978-99978-05-72-0

Сурах бичигт математик статистик, геостатистикийн аргын онолын үндсийг тайлбарлахын зэрэгцээ олон тооны жишээн дээр бодолт хийж, дүгнэлт гаргасан.



Зохиогч: Ухнаа Г., Дажидмаа Г., Ганцэцэг О.
Редактор: Алтанзул Б.
Он: 2017
Хуудас: 450
ISBN 978-99978-05-72-0

Алтын үндсэн ордын геологи, алтын ордын эрэл, хайгуул, сайн судалсан алтны зарим ордын геологи, хайгуулын ажлыг жишээн дээр авч үзсэн байна.



Зохиогч: Ухнаа Г., Алтанзул Б., П.Нарантуяа
Он: 2017
Хуудас: 161
ISBN 978-99962-4-915-0

Эрлийн торын нягтралыг өнөөчлөх магадлалын аргууд, орд ба хүдрийн биетийн геометр байгуулалтын хэсэгт хайгуулыг зүсэлт, плануудыг зохиож, хайгуулын малталт ба цроногийг өнөөчтэй төлөвлөх, хүдрийн биетийн хувирамтгай чанарын судалгаанд тулгуурлан хайгуулын сүлжлийн нягтралыг өнөөчлөх, сорьц авах арга сонгох, сорьцын үндсэн хэмжигдэхүүнийг тогтоох зэрэг олон асуудлуудыг оруулжээ.

ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААНЫ ЧИГЛЭЛЭЭР



Зохиогч: Цагаан Х., Хуягдорж М.
Редактор: Арслан Ж.
Он: 2017
Хуудас: 603
ISBN 978-99978-05-72-0

Сурах бичигт цахилгаан энергийн горимын тооцоо, агаарын шугамын механик хэсэг, агаарын шугамын гэмтлийн байрлалыг тодорхойлох, агаарын шугамын механик хэсэг, горимын тооцоо, үйлдвэрийн цахилгаан хангамж зэрэг асуудлуудыг оруулсан.




Зохиогч: Батмөнх С., Мангалжалав Ч., Даваасамбуу Ч.
Редактор: Цэрэндолгор Д.
Он: 2017
Хуудас: 200
ISBN 978-99962-3-307-4

Сурах бичигт шингэн, хийн механикийг сонгодог схемээр гидростатик, шингэн ба хийн кинематик, гидродинамик гэсэн дарааллаар авч үзэхийн зэрэгцээгээр сурах бичгийн сүүл хэсэгт инженерийн гидравликийг товч байдлаар бие даасан бүлэг болгон оруулав.



Зохиогч: Мангалжалав Ч., Баяраа Б., Цэцэгэ Ц.
Редактор: Цэрэндолгор Д.
Он: 2017
Хуудас: 122
ISBN 978-99978-1-605-4

Бодлогын хураамжид шингэн ба хийн динамик хичээлийн стандартын дагуу хийгдсэн ба хий, шингэний хөдөлгөөний зүй тогтол, үндсэн хуулиудын ойлголтыг оюутанд таниулан мэдүүлэх бодлогуудаас бүрдэнэ.



Зохиогч: Мангалжалав Ч., Баяраа Б.
Редактор: Цэрэндолгор Д.
Он: 2017
Хуудас: 68
ISBN 978-99978-1-604-7

Гарын авлага нь шингэн хийн динамик хичээлийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандартын дагуу хийгдэх хий ба шингэний хуулийн ойлголтыг оюутанд таниулан мэдүүлэх лабораторийн ажлуудтай.



Зохиогч: Жаргалхүү Д.
Редактор: Батмөнх С.
Он: 2017

Дулаан тархалтын онол 1, 2 хичээлээр бие даан хийх тооцоонуудыг оруулжээ.




Зохиогч: Мөнхзул Н., Цэвэгжав Ц., Далжжав Ш.
Редактор: Хашбат Ж., Дэлгэр Ц.
Он: 2017
ISBN 978-99962-0-094-6

Сурах бичигт автомашины цахилгаан тоноглолын хийц, ажиллах зарчим тэдгээрийн онцлогийг дэлгэрэнгүй үзүүлсэн бөгөөд бакалаврын түвшний хичээлийн сургалтын стандартын дагуу бичигдсэн.

ШУТИС-ИЙН ПРОФЕССОР БАГШ НАРЫН БҮТЭЭЛ-2017

БАРИЛГЫН ИНЖЕНЕР, АРХИТЕКТУРЫН ЧИГЛЭЛЭЭР



Зохиогч: Базар Г.
Он: 2017
Хуудас: 359
ISBN 978-99978-0-739-7

Сурах бичигт байгууламжийд үйлчлэх сейсмик хүчийн тодорхойлох, тооцох үндсэн асуудлуудыг оруулсан.



Зохиогч: Дашжамц Д.
Редактор: Энхбаатар А.
Он: 2017
Хуудас: 168
ISBN 978-99978-1-177-6

Судалгааны ажлаа эхэлж буй залуу судлаачдад сэдэв сонгохоос эхлээд судалгааны ажлын зорилго, зорилтуудыг зөв оновчтой тодорхойлох, судалгаа явуулах аргаа сонгох, хөгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг боловсруулах оюуны дүгнэлт гаргах, амьдрал үйлдвэрлэлд нэвтрүүлэх бүх шатанд шинжлэх ухааны судалгааны онол, арга зүйн мэдлэг, дадлага чадвар эзэмшүүлэхэд туслах зорилгоор энэ номоо бичив.



Зохиогч: Нямжав Н., Дуламжав Ж.
Редактор: Алтансүх Д., Болд Б.
Он: 2017
Хуудас: 186
ISBN 978-99973-32-49-3

Гарын авлагад гүүр замын байгууламжийн зургийн бүлгийг шинээр нэмж оруулав. Зураг төслийн автоматжуулсан системийн хүрээнд барилгын зураг төслийг цахимаар гүйцэтгэхэд хэрэглэсний тусгай програмыг ашиглах чадварыг оюутанд эзэмшүүлэх зорилт тавьж байна.




Зохиогч: Дашжамц Д.
Он: 2017
Хуудас: 439
ISBN 978-99973-1-178-3

Номонд чулуулгийн геологийн ангилал, хадан хөрсний физик, механикийн шинж чанар, гадны хүчин зүйлийн нөлөөгөөр чулуулгийн массив үүсэх хүчдэл, хэв гажилтын төлөв байдлыг үнэлэх онолын асуудлууд, материалын багт бэхийн онолыг чулуулгийн эвдрэлийн үнэлгээнд хэрхэн хэрэглэх талаар өгүүлсэн байна.



Зохиогч: Өлзийсүрэн Д.
Редактор: Гончигбат И., Одон С.
Он: 2017
Хуудас: 320
ISBN 978-99978-1-409-8


Номонд нэг айлын сууцны архитектур, төлөвлөлтийн аргазүй, цөөн давхар сууцны хорооллын төлөвлөлт, барилгын бүтээх, холбогдох хууль тогтоомж, норм дүрэм стандарт, гадаад болон дотоодын сурах бичиг, барилга байгууламжийн төлөвлөлтөнд шаардлагатай бусад мэдээлүүдээс оруулахыг зорив.



Зохиогч: Батцагаан Б., Батболд Ч.
Редактор: Дашжамц Д.
Он: 2017
Хуудас: 271
ISBN 978-99978-1-603-0

Сурах бичигт орчин үеийн цемент ба бетоны үйлдвэрийн хөгжлийн чиг хандлагаар технологийн гаралтай хоёрдогч нөөц баялаг, орон нутгийн түүхий эдийг ашиглах, энерги багтаамж ба бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх үүднээс авч үзнэ.

ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



Зохиогч: Баттүвшин Г., Золзааа С., Алтанцэцэг Д., Энхтуул Ц., Халиун Б., Оюунцэцэг М., Баасангэрэл Ж., Содномзул Д.
Он: 2017
Хуудас: 324
ISBN 978-99978-1-180-6

Номонд эдийн засгийн онол, практикийн асуудлуудыг өөрийн орны жишээн дээр авч тайлбарласан байна.



Зохиогч: Очирбат П.
Редактор: Амарсанаа Ж.
Эмхэтгэгч: Анар Р.
Он: 2017
Хуудас: 394
ISBN 978-99978-0-782-3

Судалгааны аргачлал, номын бүтцийн тухайд үндсэн хуулийн зүйл, заалт нэг бүрийг үндсэн хуулийн бүтцийн дагуу монгол, кирил монгол бичгээр хослуулан буулгаж, хэрэгжилтийг тухайн зүйлийн заалтын дагуу батлагдсан хууль тогтоомжийг нэрлэн жагсааж, үр дүнгийн талаар товч дурьдав.



Редактор: Золзааа С.
Он: 2017
Хуудас: 118
ISBN 978-99978-4-438-5

Энэ номонд байгууллагын дотоод болон гадаад орчны холбогдолтой асуудлуудыг оруулсан байна.

МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ЧИГЛЭЛЭЭР



Зохиогч: Дамдинсүрэн Б.
Редактор: Буянхишиг З.
Он: 2017
Хуудас: 460
ISBN 978-99978-09-74-2

Сурах бичигт тоон дохионы боловсруулалтын онол, хэрэглээ, дохио боловсруулах аргууд, тоон дохио ба систем, тэдгээрийн ангилал, ярианы синтез, автомат яриа танилт, Винерийн ба дасамжтай шүүвүүд, тэдгээрийн хэрэглээ, тоон шүүр дэх кванталлын нөлөө, үүсэх шуугиан зэргийн талаар дэлгэрэнгүй оруулсан байна.



Зохиогч: Отгонбаяр Б., Буянхишиг Б.
Редактор: Гулнар Ч., Буянхишиг Б.
Он: 2017
Хуудас: 340
ISBN 978-99978-57-17-0


Номноос хөдөлгөөнт холбооны үндэс, үндсэн нэршил, системийн сүлжээ зохион байгуулалт, үүрийг зохион байгуулах болон үүрийн загварчлал, үүрэн хөдөлгөөнт холбооны тухай ойлголтуудыг уншина.



Зохиогч: Рот Ч.Х., Кинней Ж.Л.
Орчуулагч: Амартүвшин Д., Энхзул Д., Мөнжаргал Г.
Редактор: Энхзул Д., Мөнжаргал Г.
Он: 2017
Хуудас: 470
ISBN 978-99962-1-836-1

Номонд тооллын систем, булын алгебр, булын илэрхийллийг хялбарчлах аргууд, Карно карт, квантын арга, комбинацийн болон дараалсан утгын логикууд зэрэг тоон электроникийн үндсэн ойлголтуудыг багтаасан болно.

ЕРӨНХИЙ ЭРДЭМ, СУУРЬ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР



Ерөнхий редактор Ч.Гулнар
Эрхлэгч А.Мөнхбат
Эх бэлтгэгч Ж.Өлзийхутаг

ШУТИС Хэвлэлийн газар
Утас: 90151057
И-мэйл: mustpres1057@gmail.com

ШУТИС ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЭЛ